



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 05 дугаар сарын 19 өдөр Дугаар 36

Хэрлэн сум

XXXV ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын XXXVI хурал 2020 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 11:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 88,9 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч дарга Ч.Ганбат даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. "COVID-19" өвчний цаг үеийн мэдээлэл танилцуулах:

Эрүүл мэндийн газрын дарга Ч.Оюунаа

2. "Петрочайна Дачин Тамсаг" компанийн газрын тос тээврийн туслан гүйцэтгэх компанийн тээвэрлэлтийг зогсоож хугацаатай өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг танилцуулах:

Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Мөнхтуяа

3. Автотээврийн төвөөс аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад ирүүлсэн албан бичгийг танилцуулах:

Автотээврийн төвийн дарга Ц.Мөнхтөр

4. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгаас хүмүүнлэгийн тусламж үзүүлэх хүсэлт гаргасныг хэлэлцэх:

Аймгийн ЗДТГ-ын Захиргааны удирдлагын хэлтсийн дарга Б.Алтансүх

5. Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн танилцуулга:

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Нармандах

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгаас Дорнод аймгийн Онцгой комисст хүмүүнлэгийн тусламж үзүүлэх хүсэлт гаргасныг хуралдаанаар хэлэлцэж гишүүд 100 хувь дэмжив.

Нэг. Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа-д:

1.1.Мэргэжлийн байгууллагаас өгсөн шаардлагыг биелүүлсэн “Петрочайна Дачин Тамсаг” компанийн газрын тос тээвэрлэлтийн туслан гүйцэтгэгч Жилин Ху Яан компанийн тосны тээвэрлэлт хийх үйл ажиллагааг эхлүүлж хяналт тавьж ажиллахыг,

Хоёр:Автотээврийн төвийн дарга, Онцгой комиссын
гишүүн Ц.Мөнхтөр-д:

2.1. Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношлогоог орон нутгийн хэмжээнд Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, Татварын хэлтэс, Автотээврийн төв, даатгалын байгууллагуудтай хамтран иргэдийн бөөгнөрөл үүсгэлгүй 5 хүнээс ихгүй байхаар зохион байгуулж хяналт тавьж ажиллахыг,

Гурав.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой

3.1.Дашбалбар сумын Онцгой комисст нэг удаагийн амны хаалт 200 ширхэг, гар ариутгагч /500гр/ 3 ширхэг, Гурванзагал сумын Онцгой комисст нэг удаагийн амны хаалт 200 ширхэг, гар ариутгагч /500гр/ 2 ширхэг, Булган сумын Эрүүл мэндийн төвд автомакс 1 ширхэгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас олгохыг,

3.2.Монгол улсын Шадар сайдын 2020 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 33 дугаар тушаалаар /COVID-19/ халдварт цартахалтай тэмцэх бэлэн байдлыг хангах дадлага, сургууль зохион байгуулахад нэг удаагийн амны хаалт 100 ширхэг, гар ариутгагч /300гр/ 2 ширхэгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газарт олгохыг,

Дөрөв. Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн
дарга Д.Должин-д:

3.1.Бүсийн оношлогоо эмчилгээний төвөөс аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад албан бичгээр ирүүлсэн Дотоодын хүмүүнлэгийн хандив тусламжаар тус төвд өгсөн 3 нэр төрлийн 21 ширхэг 3,0 сая төгрөгийн өртөг бүхий багаж хэрэгслийг ашиглах зөвшөөрөл олгохыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ, ОНЦГОЙ КОМИССЫН
ОРЛОГЧ ДАРГА Ч.ГАНБАТ



АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА *Д.Баттулга* Д.БАТТУЛГА